



БАТЛАВ.



АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

/Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв/
Дугаар № НТАГ-2019/16

Улаанбаатар хот

Нэг талаас **НТАГ** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **Ай Жэй Эй Эйч Аудит ХХК** (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 12 сарын 13-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох гэрээгээр аудит хийлгэх тендерийн баримт бичигт тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.

2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.

3. Захиалагч нь Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ № НТАГ-2019/16-г (цаашид “ажил” гэх) 5 500 000 /Таван сая таван зуун мянга/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;

5. Гэрээ нь энд дурдсан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

6. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

7. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдлыг арилгах үүрэг, хариуцлагыг хүлээж байна.

8. Захиалагч нь гэрээний дагуу зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдлыг арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хариуцлага хүлээж байна.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*Ц. Бат-Өлзий /Санхүүгийн
аудитын хэлтсийн дарга/*

Ц. Бат-Өлзий
Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 8 дугаар
хороо Соёлын төв өргөө, "Г"
корпус, 5 давхар
Утас/факс: 976-11-320154
Харилцагч банк - Төрийн сан,
100200024401

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Р. Алтанцэцэг /Аудитын менежер/

Р. Алтанцэцэг
Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Намьянжугийн
гудамж- Борх төв 3-р давхар 301
Утас/факс: 976-450279, 99040059
Харилцагч банк: ХААН банк-
5753906498

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ж.ЭНХЗУЛ /Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга /

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 22-р хороо,
Өлгийн гудамж,

Утас/факс: 70150065 70150067

Харилцагч банк: